

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ТАЛААР

Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргахын өмнөх улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр нийт 3.85 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байгаа ба үүнээс 2.81 тэрбум төгрөг нь эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх зорилгоор Хадгаламж банкаас авсан богино хугацаат зээл байна.

Тус зээлийн гэрээг анх 2010 оны 10 дугаар сарын 29-ны өдөр 1060/136 тоот Зээлийн гэрээгээр эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх зориулалтаар 1,900,000,000 /нэг тэрбум есөн зуун сая/ төгрөгийг сарын 1.8 хувь, жилийн 21.6 хувийн хүүтэйгээр 12 сарын хугацаатай зээлэхээр харилцан тохиролцож байгуулсныг 2011 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулан 1060/136-01 тоот гэрээг дараах нөхцөлтэйгээр байгуулсан.

Зээлийн хүүг 2011 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн сарын 1.3 хувь, жилийн 15.6 хувь, зээлийн хэмжээг 915,000,000 /есөн зуун арван таван сая/ төгрөгөөр нэмэгдүүлж 2,815,000,000 /хоёр тэрбум долоон зуун сая/ төгрөг болгон, зээл төлөгдөж дуусах хугацааг 12 сараар нэмж сунгаж, зээлийн хүүний төлбөр төлөгдөж дуусах эцсийн хугацааг 2012 оны 10 дугаар сарын 20-н хүртэл сунгасан.

